



## УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/083/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаангом сум 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: <a href="mailto:BatsuuriM@audit.gov.mn">BatsuuriM@audit.gov.mn</a> Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: <a href="mailto:Bat-Amgalanm@audit.gov.mn">Bat-Amgalanm@audit.gov.mn</a> Аудитор: Т.Ариунсайхан Утас: 70453799, Цахим хаяг: <a href="mailto:Ariunsaikhant@audit.gov.mn">Ariunsaikhant@audit.gov.mn</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	4
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	6
2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Үндсэн/.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	15
3.5.3 Нэмэлт төсөв.....	16
3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	16
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	16
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	18
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	19

## **ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМГИЙН ТАТВАРЫН  
ГАЗРЫН ДАРГА М.ГАЛСҮРЭН  
ТАНАА

᠒᠐᠒᠖.᠐᠒.᠐5 № УВА-᠒᠐᠒᠖/᠐83/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Татварын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймгийн Татварын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050-86

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>60,277,387.89</b>	<b>56,470,871.82</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>1,678.00</b>	<b>1,678.00</b>
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	1,678.00	1,678.00
31110	Төгрөг	1,678.00	1,678.00
33	<b>АВЛАГА</b>	<b>0.00</b>	<b>574,965.43</b>
335	Бусад авлага	0.00	574,965.43
3351	Байгууллагаас авах авлага	0.00	574,965.43
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>60,275,709.89</b>	<b>55,894,228.39</b>
354	<b>Хангамжийн материал</b>	<b>60,275,709.89</b>	<b>55,894,228.39</b>
35410	Бичиг хэргийн материал	2,082,252.50	1,906,060.00
35420	Аж ахуйн материал	3,447,463.60	3,447,463.60
35430	Сэлбэг хэрэгсэл	81,000.00	81,000.00
35470	Бусад хангамжийн материал	54,664,993.79	50,459,704.79
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,493,665,005.36</b>	<b>2,425,771,818.25</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,493,665,005.36</b>	<b>2,425,771,818.25</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,473,665,005.36</b>	<b>2,405,771,818.25</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,392,623,600.00	2,392,623,600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-85,697,448.16	-125,795,932.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	119,000,000.00	119,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-89,564,681.70	-93,312,114.80
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	285,538,263.37	270,980,164.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-190,379,905.77	-194,405,973.96
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,772,676.50	92,024,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-51,724,940.85	-57,217,487.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,671,400.00	6,892,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,573,958.03	-5,016,438.14
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>20,000,000.00</b>	<b>20,000,000.00</b>
39301	Программ хангамж	480,000.00	480,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-480,000.00	-480,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,553,942,393.25</b>	<b>2,482,242,690.07</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>1,004,627.04</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>1,004,627.04</b>
413	<b>Өглөг</b>	<b>0.00</b>	<b>1,004,627.04</b>
4136	Бусад өглөг	0.00	1,004,627.04
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	0.00	735,000.00
41365	Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/	0.00	269,627.04
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,553,942,393.25</b>	<b>2,481,238,063.03</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,553,942,393.25</b>	<b>2,481,238,063.03</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	249,245,746.77	249,245,746.77
51101	Өмч: - төрийн	249,245,746.77	249,245,746.77
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,212,507,899.51</b>	<b>2,139,803,569.29</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,361,863,141.55	2,212,507,899.51
51220	Тайлант үеийн үр дүн	-149,355,242.04	-72,704,330.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	92,188,746.97	92,188,746.97
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,553,942,393.25</b>	<b>2,482,242,690.07</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,757,182,700.00</b>	<b>2,666,634,441.23</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>23,849,000.00</b>	<b>37,063,324.23</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>23,849,000.00</b>	<b>37,063,324.23</b>
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	0.00	11.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	23,849,000.00	37,063,313.23
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,733,333,700.00</b>	<b>2,629,571,117.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,632,378,600.00</b>	<b>2,531,006,717.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,632,378,600.00	2,531,006,717.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>98,564,400.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	97,064,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,500,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>100,955,100.00</b>	<b>0.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	100,955,100.00	0.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,906,537,942.04</b>	<b>2,733,681,953.61</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,906,537,942.04</b>	<b>2,733,681,953.61</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,565,393,048.24</b>	<b>2,671,368,574.93</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,847,859,821.17</b>	<b>2,034,516,191.46</b>
210101	Үндсэн цалин	825,602,607.20	911,016,240.46
210102	Нэмэгдэл	534,896,261.91	544,436,331.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	82,644,181.41	180,587,879.07
210104	Урамшуулал	404,716,770.65	398,475,740.44
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>229,847,036.52</b>	<b>255,049,331.43</b>
210201	Тэтгэврийн даатгал	158,262,515.49	175,831,150.35
210202	Тэтгэмжийн даатгал	18,614,697.83	20,627,316.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,241,349.01	10,209,378.38
210204	Ажилгүйдлийн даатгал	8,745,694.91	9,676,297.33
210205	Эрүүл мэндийн даатгал	34,982,779.28	38,705,188.90
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>73,722,995.21</b>	<b>95,377,128.04</b>
210301	Гэрэл цахилгаан	11,299,995.21	13,557,386.03
210302	Түлш, халаалт	57,783,000.00	75,748,895.01
210303	Цэвэр, бохир ус	4,640,000.00	6,070,847.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>40,062,500.30</b>	<b>42,413,386.50</b>
210401	Бичиг хэрэг	7,899,960.00	9,111,242.50
210402	Тээвэр, шатахуун	13,400,000.00	12,098,300.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,573,210.10	3,716,544.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,189,330.20	17,487,300.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,544,000.00</b>	<b>29,482,000.00</b>
210604	Урсгал засвар	17,544,000.00	29,482,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>28,508,150.00</b>	<b>1,340,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	28,508,150.00	1,340,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>96,744,303.00</b>	<b>91,891,055.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	95,492,095.00	91,282,155.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	170,800.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	179,808.00	183,300.00

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	0.00
210807	Газрын төлбөр	425,600.00	425,600.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>231,104,242.04</b>	<b>121,299,482.50</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,900,000.00	2,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	203,204,242.04	119,299,482.50
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>341,144,893.80</b>	<b>62,313,378.68</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>231,533,462.00</b>	<b>46,129,417.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,600,320.00	26,820,617.20
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	180,436,142.00	17,148,799.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,497,000.00	2,160,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>109,611,431.80</b>	<b>16,183,961.68</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	109,611,431.80	16,183,961.68
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-149,355,242.04</b>	<b>-67,047,512.38</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>5,656,817.84</b>
225001	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	0.00	5,656,817.84
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>0.00</b>	<b>-5,656,817.84</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-149,355,242.04</b>	<b>-72,704,330.22</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,733,333,700.00</b>	<b>2,629,571,117.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,733,333,700.00</b>	<b>2,629,571,117.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,632,378,600.00</b>	<b>2,531,006,717.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,632,378,600.00	2,531,006,717.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>98,564,400.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	97,064,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,500,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>100,955,100.00</b>	<b>0.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	100,955,100.00	0.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,703,333,700.00</b>	<b>2,609,571,317.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,703,333,700.00</b>	<b>2,609,571,317.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,362,188,806.20</b>	<b>2,547,257,938.32</b>
2101	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,847,859,821.17</b>	<b>2,024,859,715.32</b>
210101	Үндсэн цалин	825,602,607.20	887,751,471.90
210102	Нэмэгдэл	534,896,261.91	550,117,028.41
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	82,644,181.41	177,580,511.39
210104	Урамшуулал	404,716,770.65	409,410,703.62
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>229,847,036.52</b>	<b>264,566,123.35</b>
210201	Тэтгэврийн даатгал	158,262,515.49	196,560,958.78
210202	Тэтгэмжийн даатгал	18,614,697.83	17,659,826.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,241,349.01	8,757,263.47
210204	Ажилгүйдлийн даатгал	8,745,694.91	8,317,574.96

210205	Эрүүл мэндийн даатгал	34,982,779.28	33,270,499.47
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>73,722,995.21</b>	<b>95,377,128.04</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,299,995.21	13,557,386.03
210302	Түлш, халаалт	57,783,000.00	75,748,895.01
210303	Цэвэр, бохир ус	4,640,000.00	6,070,847.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>40,062,500.30</b>	<b>38,031,894.00</b>
210401	Бичиг хэрэг	7,899,960.00	8,935,050.00
210402	Тээвэр, шатахуун	13,400,000.00	12,098,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,573,210.10	3,716,544.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,189,330.20	13,282,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,544,000.00</b>	<b>29,482,000.00</b>
210604	Урсгал засвар	17,544,000.00	29,482,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>28,508,150.00</b>	<b>1,340,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	28,508,150.00	1,340,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>96,744,303.00</b>	<b>91,601,077.61</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	95,492,095.00	90,992,177.61
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	170,800.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	179,808.00	183,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	0.00
210807	Газрын төлбөр	425,600.00	425,600.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	27,900,000.00	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,900,000.00	2,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>341,144,893.80</b>	<b>62,313,378.68</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>231,533,462.00</b>	<b>46,129,417.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,600,320.00	26,820,617.20
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	180,436,142.00	17,148,799.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,497,000.00	2,160,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	109,611,431.80	16,183,961.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	109,611,431.80	16,183,961.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	30,000,000.00	19,999,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	30,000,000.00	19,999,800.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>30,000,000.00</b>	<b>19,999,800.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	30,000,000.00	19,999,800.00
223001	Бусад хөрөнгө	30,000,000.00	19,999,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-30,000,000.00	-19,999,800.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,678.00</b>	<b>1,678.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,678.00</b>	<b>1,678.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	249,245,746.77	92,188,746.97	2,361,863,141.55	0.00	2,703,297,635.29
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>249,245,746.77</b>	<b>92,188,746.97</b>	<b>2,361,863,141.55</b>	<b>0.00</b>	<b>2,703,297,635.29</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-149,355,242.04	0.00	-149,355,242.04
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,245,746.77	92,188,746.97	2,212,507,899.51	0.00	2,553,942,393.25
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	249,245,746.77	92,188,746.97	2,212,507,899.51	0.00	2,553,942,393.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	262,914.68	00.00	262,914.68
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>249,245,746.77</b>	<b>92,188,746.97</b>	<b>2,212,507,899.51</b>	<b>0.00</b>	<b>2,553,942,393.25</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00

D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-72,704,330.22	0.00	-72,704,330.22
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,245,746.77	92,188,746.97	2,139,803,569.29	0.00	2,481,238,063.03

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Үндсэн/

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,678.00	-1,678.00
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,577,995,200.00</b>	<b>2,514,862,847.51</b>	<b>63,132,352.49</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,577,995,200.00</b>	<b>2,514,862,847.51</b>	<b>63,132,352.49</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,531,957,400.00</b>	<b>2,470,233,430.51</b>	<b>61,723,969.49</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,984,201,600.00</b>	<b>1,958,147,478.90</b>	<b>26,054,121.10</b>
Үндсэн цалин	959,564,500.00	881,714,727.58	77,849,772.42
Нэмэгдэл	531,883,200.00	489,441,536.31	42,441,663.69
Унаа хоолны Хөнгөлөлт	105,657,300.00	177,580,511.39	-71,923,211.39
Урамшуулал	387,096,600.00	409,410,703.62	-22,314,103.62
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>263,385,600.00</b>	<b>256,253,851.96</b>	<b>7,131,748.04</b>
Тэтгэврийн даатгал	188,696,100.00	190,856,339.21	-2,160,239.21
Тэтгэмжийн даатгал	18,698,900.00	16,988,694.97	1,710,205.03
ҮОМШӨ-ний даатгал	9,346,800.00	8,421,697.62	925,102.38
Ажилгүйдлийн даатгал	9,328,800.00	7,997,384.12	1,331,415.88
Эрүүл мэндийн даатгал	37,315,000.00	31,989,736.04	5,325,263.96
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>106,587,400.00</b>	<b>95,377,128.04</b>	<b>11,210,271.96</b>
Гэрэл, цахилгаан	13,522,300.00	13,557,386.03	-35,086.03
Түлш, халаалт	85,229,900.00	75,748,895.01	9,481,004.99
Цэвэр, бохир ус	7,835,200.00	6,070,847.00	1,764,353.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>47,661,200.00</b>	<b>38,031,894.00</b>	<b>9,629,306.00</b>
Бичиг хэрэг	11,435,200.00	8,935,050.00	2,500,150.00
Тээвэр, шатахуун	12,098,400.00	12,098,300.00	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,188,800.00	3,716,544.00	472,256.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,938,800.00	13,282,000.00	6,656,800.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>29,482,000.00</b>	<b>29,482,000.00</b>	<b>0.00</b>
Урсгал засвар	29,482,000.00	29,482,000.00	0.00
<b>Томилolt, зочны зардал</b>	<b>7,122,700.00</b>	<b>1,340,000.00</b>	<b>5,782,700.00</b>
Дотоод албан томилolt	7,122,700.00	1,340,000.00	5,782,700.00

<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>93,516,900.00</b>	<b>91,601,077.61</b>	<b>1,915,822.39</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	92,231,900.00	90,992,177.61	1,239,722.39
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	0.00	432,000.00
Даатгалын үйлчилгээ	200,100.00	0.00	200,100.00
Тээврийн хэрэгслийн татвар	183,500.00	183,300.00	200.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	43,800.00	0.00	43,800.00
Газрын төлбөр	425,600.00	425,600.00	0.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>46,037,800.00</b>	<b>44,629,417.00</b>	<b>1,408,383.00</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>46,037,800.00</b>	<b>44,629,417.00</b>	<b>1,408,383.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,454,200.00	26,820,617.20	633,582.80
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,923,600.00	17,148,799.80	774,800.20
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	660,000.00	660,000.00	0.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,577,995,200.00</b>	<b>2,514,862,847.51</b>	<b>63,132,352.49</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,577,995,200.00</b>	<b>2,514,862,847.51</b>	<b>63,132,352.49</b>
Улсын төсвөөс санхүүжих	2,577,995,200.00	2,514,862,847.51	63,132,352.49
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>1,678.00</b>	<b>-1,678.00</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>1,678.00</b>	<b>-1,678.00</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төсвийн гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>98,524,307.94</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>98,524,307.94</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>98,524,307.94</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>66,712,236.42</b>
Үндсэн цалин	6,036,744.32
Нэмэгдэл	60,675,492.10
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>8,312,271.52</b>
Тэтгэврийн даатгал	5,704,619.70
Тэтгэмжийн даатгал	671,131.70
ҮОМШӨ-ний даатгал	335,565.85
Ажилгүйдлийн даатгал	320,190.84
Эрүүл мэндийн даатгал	1,280,763.43
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,000,000.00</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	2,000,000.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,500,000.00</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,500,000.00</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>19,999,800.00</b>
Дотоод эх үүсвэрээр	19,999,800.00
Бусад хөрөнгө	19,999,800.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>98,564,400.00</b>

ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,064,400.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Татварын газар нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, улс, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэх, хүний нөөц, төсөв санхүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Татварын газар нь захиргаа, хуулийн тасаг, бичил татвар төлөгчтэй харилцах тасаг, жижиг татвар төлөгчидтэй харилцах тасаг, татварын хяналт, шалгалтын тасаг гэсэн 4 тасагтайгаар 45 албан хаагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант онд “Зөвлөн туслагч, Татварын алба” гэсэн зорилт дэвшүүлэн татвар төлөгчдийг эрсдэлээс хамгаалах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Увс аймгийн Татварын газрын төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах нэмэлт, өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон;
- Төрийн албаны тухай хуульд – 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Төсвийн тухай хуульд - 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд

дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлсөн байна.

Увс аймгийн Татварын газар нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн "Emerald" программ ашиглан бэлтгэж, Татварын Ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/156 дугаар тушаалаар батлуулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг жишиг болгон мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71,699.7 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1.7	1.7	-
Авлага	0.0	575.0	575.0
Бараа материал	60,275.7	55,894.2	(4,381.5)
Үндсэн хөрөнгө	2,493,665.0	2,425,771.8	(67,893.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,553,942.4</b>	<b>2,482,242.7</b>	<b>(71,699.7)</b>
Өр төлбөр	-	1,004.6	1,004.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,553,942.4	2,481,238.1	(72,704.3)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,553,942.4</b>	<b>2,482,242.7</b>	<b>(71,699.7)</b>

Мөнгөн хөрөнгийн данс тайлант оны эхэнд болон эцэст 1.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага данс оны эхэнд үлдэгдэлгүй, эцэст 575.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 55,894.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,381.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,425,771.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 67,893.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 72,149.3 мянган төгрөгийн хөрөнгө акталсан нь гол нөлөө үзүүлжээ.

Тайлант онд 1,004.6 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,481,238.1 мянган төгрөг болж, 72,704.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,743,328.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,743,328.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 332,767.2 мянган төгрөгөөр бууруулж, 2,410,561.5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 167,433.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,577,995.2 мянган төгрөг болгон тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр төсвөөс 2,531,006.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаанд 2,514,862.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,514,862.8 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 26,054.1 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 7,131.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 11,210.3 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 9,629.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1,915.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал/ 70205-80101/	2,439,725.5	2,379,241.3	(60,484.2)	97.5%
2	Мэдээлэл сурталчилгааны зардал/70205-80205/	250.0	250.0	-	100.0%
3	Харуул хамгаалалтын зардал /70205-80219/	43,097.9	41,858.2	(1,239.7)	97.1%
4	Холбооны суваг ашигласны хөлс /70205-80220/	48,884.0	48,884.0	-	100.0%
5	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал /70205-80802/	46,037.8	44,629.4	(1,408.4)	96.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

*/мянган төгрөг/*

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	-	-	Нягтлан бодох бүртгэлийн "Emerald" программыг ашиглаж байна.
2	Унаа, хоолны зарцуулалт	105,657.3	177,580.5	Татварын газрын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/36 тушаалаар нэг хүнд ногдох 1 өдрийн хоолны тарифыг 18.0 мянган төгрөгөөр тогтоож, тайлант онд 177,580.5 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна.
3	Сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардал	2,000.0	2,000.0	Увс аймгийн Татварын газрын албан хаагчдын нэгдсэн сургалтыг зохион байгуулж, бичиг хэрэг болон өдрийн хоолны зардал гаргасан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	-	-	Зардал гараагүй
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	-	-	Зардал гараагүй
6	Орон тоо	2,050,952.6	2,024,859.7	2024 онд 46 орон тоо батлагдсан бөгөөд тайлант онд 45 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулсан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнөөс 97,064.4 мянган төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнөөс 1,500.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авснаас цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардалд 66,712.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын зардалд 8,312.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Увс аймгийн Татварын газарт тайлант онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улаангом сумын Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалтын зардал дээр тавигдсан Аймгийн Татварын газарт тоног төхөөрөмж худалдан авах арга хэмжээг 2025 оны

06 дугаар сарын 10-ны өдөр Улаангом сумын ЗДТГ-аас Аймгийн татварт эрх шилжүүлсэн байна. Тоног төхөөрөмж худалдан авах 20,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээг холбогдох хууль журмын дагуу шууд худалдан авалт хийж, данс бүртгэлд тусгасан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Татварын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Ариунсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт Увс аймгийн Татварын газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 24 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,906,537.9 мянган төгрөгийн 1 хувиар буюу 18,947.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 15,158.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,733,682.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 27,332.5 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 21,869.5 мянган төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Татварын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс аймгийн Татварын газар нь тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 165, хугацаа хоцроосон 4, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Увс аймгийн Татварын газрын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн бөгөөд Татварын ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар баталсан "Татварын ерөнхий газрын харьяа нэгж, нийслэлийн татварын газар, дүүргийн татварын хэлтсийн орон тооны хязгаар"-т "хураагч" гэсэн албан тушаал байхгүй байхад 1 хураагч ажиллуулсан алдаа, зөрчил илэрсэн. Хураагчийг аймгийн Татварын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Б/29 дүгээр тушаалаар албан тушаалаас чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалж зөрчлийг арилгасан байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар 22,989.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 1 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 1,579.6 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа.

#### **Залруулсан алдаа:**

Хувь хүний орлогын албан татварын 269.6 мянган төгрөг, Шүүхийн шийдвэрийн дагуу хүүхдийн тэтгэлгийн төлбөртэй нэг гүйцэтгэх баримт бичгийн 735.0 мянган төгрөг, нийт 1,004.6 мянган төгрөгийн өглөг, нийгмийн даатгалын шимтгэлийн 575.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайландаа тусгаагүй орхигдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4 дэх заалтад "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2

дэх заалтад “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.3 дахь заалтад “бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5 дахь заалтад “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хувь хүний орлогын албан татварын 269,627.04 төгрөг, Шүүхийн шийдвэрийн дагуу хүүхдийн тэтгэлгийн төлбөртэй нэг гүйцэтгэх баримт бичгийн 735,000.0 төгрөгийн үлдэгдэл, нийт 1,004,627.0 төгрөгийг өглөг, Нийгмийн даатгалын шимтгэлийн 574,965.43 төгрөгийн авлагыг санхүүгийн тайландаа тусгаагүй.	1	1,579.6	1	1,579.6			1	1,579.6				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,579.6</b>	<b>1</b>	<b>1,579.6</b>			<b>1</b>	<b>1,579.6</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Байхгүй													
Дүн													

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байхгүй								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Байхгүй								
Дүн								
Нийт дүн								

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.АРИУНСАЙХАН/

2026.02.05